

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Ц. БААТАР

Бүгд Найрамдах Солонгос Улс /БНСУ/ Ази тивийн Зүүн хойтхэсэгт оршино. 99, 2 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай. Энэ нь Солонгосын хойгийн нийт нутгийн 45 хувь нь гэсэн үг. Газар нутаг нь хойноосоо урагшаа 100 км сунаж тогтсон байрлалтай. Хүн ам 43, 5 сая /1990 оны байдлаар/. Нийслэл нь Сеул 11 сая хүн сууна. Хүн амын 65, 4 хувь нь хотод оршин сууна. 1990 оны байдлаар нэг сая, түүнээс дээш хүн амтай хот Өмнөд Солонгост 5 байв. Хүн ам нь үндсэндээ солонгосчууд юм. Цөөн тооны хятад угсаатан бий. Улсын хэл нь солонгос. Солонгос хэл Урал-Алгайн хэлний бүлэгт орно. Солонгосчууд англи хэл өргөн ашиглана. Шашин шүтлэгийн хувьдолон янз, зонхилох шашин нь бурхны, христосын, лалын шашин болно.

БНСУ-ын хууль тогтоох төрийн дээд байгууллага нь Үндэсний Ассамблей. Ерөнхийлөгчийн засаглалтай Бүгд Найрамдах улс юм. БНСУ-ын төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч болно. Энэ орны үндсэн хуулиар дотоод, гадаад бодлогын салбарт Ерөнхийлөгч өргөн эрх мэдэлтэй байдаг. Ерөнхийлөгчийг таван жилийн хугацаагаар сонгодог бөгөөд тэрбээр дахин сонгогдох эрх эдэлдэггүй. 1992 оны арван хоёрдугаар сарын сүүлчээр болсон Ерөнхийлөгчийн сонгуульд Либерал-ардчилсан намаас нэр дэвшсэн Ким Ен Сам олонхийн санал авч бусад зургаан өрсөлдөгчөөсөө түрүүлжээ. Ийнхүү Өмнөд Солонгост сүүлийн гучин жилд анх удаа цэргийн бус хүн Ерөнхийлөгчөөр сонгогдож, энэ оронд "Цэргийн засаглалын эрин" эцэс болов. Ким Ен Сам БНСУ-ын долоо дахь Ерөнхийлөгч нь болж байна.

БНСУ 1991 оны есдүгээр сарын 17-нд НҮБ-д гишүүнээр элссэн. Одоо 150 гаруй оронтой дипломат харилцаатай, үүнээс 100 гаруй оронтой элчин сайдын хэмжээнд харилцаж байна.

Мөнгөн тэмдэгтийг нь вон гэнэ. 770 вон нэг ам. доллартай тэнцэж байв. 1992 оны байдлаар/

БНСУ засаг захиргааны хувьд Сненгги, Кангвон, Чунгчаргнам, Чунгченгбук, Чедлабук, Челланам, Киенгсангнам, Киенгсанчвук, Чэжү гэсэн 9 муж, нийтдээ 56 дүүрэг бүхий 6 томоохон хотоос бүрдэл болно. Өмнөд Солонгос эвлэлийн байдлаар 123 хот, 36000 тосгонтой.

Улс орны нийгэм-эдний засгийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг саяас дээш хүн амтай аж үйлдвэрийн томоохон төв болсон хотууд гэвэл 22 дүүрэгтэй Сеул, 12 дүүрэгтэй Пусан, 7 дүүрэгтэй Тху, 6 дүүрэгтэй Инчон, 4 дүүрэгтэй Куанжу, 3 дүүрэгтэй Тижэн юм. Өмнөд Солонгос баруунаараа шар тэнгис, зүүнээрээ Дорнод тэнгис, өмнүүрээ Япон тэнгисээр хүрээлэгдэнэ. Газар нутгийн 70 хувийг уул нуруу эзэлнэ. Уулсын хамгийн өндөр нь далайн түвшнээс дээш 2744 метр өргөгджээ. Солонгосод том жижиг 3000 арал бий. Үүнээс хамгийн том нь

МОНГОЛЧУУДЫН ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ ЧЭЖҮ АРАЛ ЮМ. Хойноосоо урагш чиглэн урсдаг Амнок /790 км/, Түмэн /521/, Нактонг /525 км/, Хан /514 км/ зэрэг томоохон гол мөрөнтэй. Эдгээр гол мөрөн улс ардын аж ахуйд чухал үүрэг гүйцэтгэдэг. Далайн зөөлөн дулаан, чийглэг уур амьсгалтай. Өвөлдөө -12 хэм хүйтэрч, зундаа 30, 6 хэм хална. Хурьн улирал нь зургээ, долоо, наймдугаар сар юм. Байгалийн баялгаар хомс. Газрын хэвчлэлд гянт болд, анзан, цайр, бал, шөрмөсөн чулуу, каолин зэргээс бусад эрдсээр ховор. Улс орны эдийн засагт эн тэргүүний онцгой чухал хэрэгцээт түүш, төмөр, хөнгөн цагаан, дин зэрэг 20 гаруй үндсэн нэр төрлийн түүхий эдийг гаднадаас 90-100 хувь авдаг. Хэднэгээр байгалийн нөөц баялгаар ийм хомс байгаа ч гэсэн газар зүйн байрлалыг орон судлалын үүднээс авч үзвэл хамгийн ашигтай байрлалд оршдог. Өмнөд Солонгос дэлхийн хотуудын төв хэмээн нэрлэгддэг Токиотой бусад аль ч орныхоос ойр оршдог. Дэлхийн хамгийн том зах зээлд тооцогддог Бээжинтэй хаяа дэрлэдэг. Токио Бээжинг зураасаар холбоход шулуун шугамын бараг тэхий голд Сеул хот оршино. Энэ бүхнээс үзэхэд Солонгос орон дорнын соёлын их замын нэгэн томоохон буурчийн газар гэлтэй. Өнөөдөр энэ замаар Японы шинжлэх ухаан техникийн орчин үеийн шинэхэн нээлт ололтууд Солонгосыг дайран Хятад улсад хүрч байна. Энэ орныг Зүүн хойт Азийн бүс нутаг гэдэг ойлголтын үүднээс аваад үзсэн ч хамгийн ашигтай байрлалд байна. Өөрөөр хэлбэл АНУ, Япон, Хятадыг холбосон том гурвалжны төв хэсэгт БНСУ байрлаж байна.

Солонгосчууд өнө эртний баялаг түүхтэй ард түмэн. Солонгос угсаатан оршин тогтносоор 5 мянга гаруй жилийн түүхийг туулжээ. Солонгосад тэрт ёс буй болсоор 4325 жилийн нүүр үзэж байна. Солонгосын хойгт оршин тогтнож байсан хамгийн эртний төр улс нь Чосон гүрэн юм. Чосон нь манай эртний өмнөх V-IV зуунд ихээхэн хөгжсөн улс байжээ. Манай эртний эхний зуунуудад Солонгосын хойгт Когурно, Пэгчэ, Силла гэсэн эртний феодалын улсууд үүсч оршин тогтнож байгаад X зууны эцсээр Солонгосын хойгийг бүхэлд нь нэгтгэсэн Корё улс байгуулагдсан байна. Энэ үеэс өрнөдийнхэн "Корей" гэж нэрлэх болсон гэдэг. Дорно дахины зарим судар бичигт "гуудин улс" гэж гардаг. "Монголын нууц товчоо"-нд гардаг "Солонгос" хэмээх үгийн гарлыг судлагчид янз бүрээр авч үздэг. Эрдэмтдийн олонхи нь "солонгос" гэдэг үг монгол хэлний "солонго" гэдэг үгнээс үүсэлтэй гэж үздэг бөгөөд түүнийг солонгос хүүхдийн үндэсний хувцасны хандуйг өнөө хүртэл солонгын өнгөөр ялган хийдэг өвөрмөц заншилтай холбоо тэйлбарладаг.

Солонгос угсаатан бий болсон түүхийг төхөж үзвэл тэд Хүннү гүрний үеэс монголтой хил залган нутаглаж байсан төвийгүй Солонгосын зарим аймаг эрт цагт Алтайгаас Орхон, Сэлэнгэ, Дорнодын тал нутгийг дамжин нүүдэллэн явсаар Солонгосын хойгт суурьшсан гэдэг. Монголын эзэнт гүрний үед энэхүү хэлхээ холбоо улам өргөжинж солонгосчууд монголын эзэнт гүрний хараат, заримдаа холбоотон болж явсан түүхтэй. Когурно, Пэгчэ, Силла буюу гурван улсын үеэс солонгосчууд түүх, соёлын дурсгалээрээ алдартай. Дундад зууны үед солонгосын ард түмэн харьин булагч эзлэгчдийн эсрэг нэг биш удса зэвсэг барин тэмцэж байсан түүхтэй. Япон улс 1876 онд Солонгост анхны тэгш бүс худалдааны хэлэлцээрийн тулган хүлээлгэсэн бөгөөд 1905 оны арван нэгдүгээр сард Солонгост өөрийн захиргааг тогтоож, улмаар 1910 онд "Солонгосыг нийлүүлэх тухай Гэрээ" байгуулж түүнийг Японы нэг муж гэж зарлажээ. Тэр цагаас хойш Солонгос орон 1945 оны наймдугаар сар хүртэл Японы ноёрхолд байв. 1945 онд колониалаас ангижирсан боловч авхай л том гүрнүүдийн сөргөлдөөнд өртөж Солонгосын хойг хоёр хэсэгт хуваагджээ. Чухам энэ үеэс буюу 1948 оноос Сеул нийслэлтэй БНСУ-ын шинэхэн түүх эхэлсэн билээ. Энэ үеийн Өмнөд Солонгосын нийгэм-эдийн засгийн амьдрал үнэхээр хурд хэцүү байв. Хуваагдмал нөхцөлд улс орноо төвхнүүлэх, засгийн эрхийн төлөө

врсөлдөөн, тэмцлийг зохицуулах зэрэг ихээхэн төвөгтэй олон талт асуудлыг шийдвэрлэхэд цаг хугацаа, хүч чармайлт гаргах шаардлагатай байлаа. Солонгосын хойг хоёр хэсэгт хуваагдахаас өмнө үйлдвэрлэлийн бүтцийн хувьд "умард хэсэг нь аж үйлдвэр, өмнөд хэсэг нь газар тариалан" гэсэн чиглэлээр явж ирсэн учир өмнөд хэсэгт аж үйлдвэр төдийлөн хөгжөөгүй байжээ. Газар тариалангийн салбар зонхилох байр суурьтай байсан боловч дорвитой хөгжиж чадаагүй байв. Улс орны эдийн засаг нийгмийн амьдрал улам бүр хүндэрч байсан үед солонгосын хойгийн хоёр хэсгийн хооронд дайн эхлэв. 1950-1953 он хүртэл бүтэн гурван жил үргэлжилсэн энэ дайнаар хоёр хэсгийн эдийн засаг, аж ахуй сүйрлийн байдалд орсон байна. Зөвхөн өмнөд хэсэгт учирсан материаллаг хохирол гэхэд л тэр үеийн БНСУ-ын хоёр жилийн үндэсний нийт бүтээгдэхүүний нийлбэртэй тэнцэж байсан гэсэн баримт бий. Үгүйрэл ядууралын туйлд хүрч, өлсгөлөн улс орныг бүхэлд нь хамрав. Энэ байдал 1960 он хүртэл үргэлжилсэн байна. Энэ үед олон улсын байдал ч хүнд байв. Энэ хүнд хэцүү байдлын дунд 1961 онд тус оронд цэргийн засаглал тогтож улс орны удирдах үүргийг өөртөө хүлээжээ.

Цэргийн засаг захиргааныхан удирдлагын эрхийг гартаа авмагц улс орноо хөгжүүлэх үндсэн чиглэл боловсруулж түүнийг хэрэгжүүлэхийн тулд 1962 оноос таван жилийн төлөвлөгөөг зохиож эхлэв. Түүнээс хойш 6 таван жилийн төлөвлөгөөг биелүүлж, одоо ҮП таван жилийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлж байна. Солонгосын төлөвлөлтийн онцлог нь хөгжлийн чиг хандлага, бодлогоо тодорхойлодогт оршино. Эдийн засаг, нийгмийн салбарт тухайн жилд болон 5 жилд баримталж, хэрэгжүүлэх бодлогоо олон талаас нь нарийвчлан төлөвлөөд батлагдмагц улс орны бүхий л хүчийг түүнд чиглүүлдэг байна. Улс орноо үйлдвэржүүлэх программыг шийдвэрлэсэн эрэмбэ дараа явцыг авч үзэхэд дээрх байдал тодорхой харагддаг. Энэхүү программын эхний шатанд гол төлөв импортын бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх чиглэл баримталсан. Үүний дагуу бүх хүчээ төвлөрүүлж төмөрлөгийн үйлдвэрийн цогцолбор барьж ашиглалтад оруулсан. Энэ нь улс орны амьдралд шийдвэрлэх ач хөлбогдолтой үйл явдал болсон байна. Ингэснээр импортоор авдаг бүтээгдэхүүнийг өөртөө үйлдвэрлэх явдал аажим аажмаар нэмэгдэн улмаар зонхилох шинжтэй болжээ. Үүний хажуугаар үндэсний хөрөнгөтний зарим хэсэгт экспортын чиглэлээр хөнгөн үйлдвэрүүд хөгжүүлж ирсэн байна.

Экспортын хүчин чадлыг нэмэгдүүлж, эдийн засгийн суурь, салбарыг хөгжүүлэх асуудлыг хөгжлийн хоёр дахь шатанд чухалчлан анхаарав. 1967-1971 оны II таван жилийн төлөвлөгөөнөөс эхэлж 1970-аад оны сүүлч хүтэл үргэлжилсэн хоёр дахь шатны үндсэн зорилт нь эхний шатанд авсан арга хэмжээгээ бататгахын дээр экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн төмөрлөг, хими, машины үйлдвэрийг түүхүү хөгжүүлжээ. Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр засгаас онцгой анхаарч түүнд хөнгөлөлттэй зээл олгох, үйлдвэртээ зориулж импортоор авах зүйлийг нь гаалийн татвараас хөнгөлөх буюу чөлөөлж байв. Мөн шинээр экспортод зориулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь гаалийн болон ашиг орлогын татвараас чөлөөлөх, хөнгөлөх арга хэмжээ авч иржээ. Энэ бүх арга хэмжээний үр дүнд экспортын чиглэлийн үйлдвэрлэлийн салбар 80-аад оноос илүү хурдацтай хөгжиж эхэлсэн байна. Тийм ч учраас Өмнөд Солонгосын үсрэнгүй хөгжлийг экспортод чиглэсэн "эдийн засгийн гайхамшиг" гэж нэрлэх нь ч бий. Эдүгээ экспортод зүйлсийнхээ 90 гаруй хувийг бүрэн боловсруулсан чанар, үзэмж сайтай харьцангуй хямд бүтээгдэхүүн болгон гаргаж байна. Өмнөд Солонгосын экспорт 1989 оны байдлаар 62,4 тэрбум ам. долларт хүрчээ. Үүнд хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүн 53,6 хувь, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн 39,7 хувь, хүнс өргөн хэрэглээний бараа 4 хувь, түүхий эл түлш шатахуун 2,7 хувийг тус тус эзэлж байна. Өнөөгийн шатанд хөдөлмөрийн оролцоо ихтэй бөс дагуу, бэлэн хувиас, гутлын зэрэг хөнгөн үйлдвэрийн салбараас хөрөнгө оруулалт ихдээ хүнд

Гангийн болон хөдөө аж ахуйн үйлдвэрийн салбарыг түлхүү хөгжүүлэх чиглэл баримталж байна. Сүүлийн жилүүдэд өндөр технологийн хагас дамжуулагч, цахим техникийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарууд амжилттай хөгжиж байна. Одоо БНСУ телевизор, видеокассет олшруулагч, микродолгионы зуух зэрэг удаан эдэлгээтэй бүтээгдэхүүний гол экспортлогч болжээ. 1989 оны байдлаар II сая 580 мянган өнгөт телевизор, 9 сая 98 мянган видеоманитофон, 2 сая 803 мянган хөргөгч, сая 864 мянган угзалгын машин, 846 мянган суудлын, 163 мянган ачааны, 79 мянган автобус үйлдвэрлэжээ. Цахилгаан эрчим хүчнийхээ 7 хувийг импортоор хангаж байна. Цөмийн эрчим хүч цахилгаан эрчим хүчний хэрэгцээний 10 хувийг хангана. БНСУ үйлдвэржүүлэх бодлогыг хэрэгжүүлэхдээ эхний шатанд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг экспортын чиглэлээр хөгжүүлэхэд илүү их анхаарал тавьсан байна. Энэ нь ч зохих үр дүнгээ өгчээ. Экспортолсон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээрээ гадаадын дэвшилтэй техник технологи их хэмжээгээр худалдан авч өөрийн болгон ашиглаж чадсан явдал үйлдвэржүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд их үүрэг гүйцэтгэжээ. Түүнчлэн хөдөө аж ахуйн салбар, түүний дотор газрын том эздийг аж үйлдвэрт хөрөнгө оруулах чиглэлээр урамшуулсан явдал зохих үр дүнгээ өгсөн байна. Улсын татварын алба хөрөнгө хуримтлуулан төвлөрүүлж улсын чанартай томоохон төслийг хэрэгжүүлэхэд ихээхэн тус дэхом үзүүлсэн байна.

Өмнөд Солонгос нь эхний үед улсын секторын үйлдвэрийг хөгжүүлэхэд голлон анхаарч түүнд ихээхэн хөрөнгө хүч зарцуулсан байна. Яваандаа хөгжлийн зохих түвшинд хүрсний дараа төрийн онцгой хяналтанд байх улсын өмчөөс бусад үйлдвэр аж ахуйн газрыг янз бүрийн хэлбэр, үе шаттайгаар хувьчлах ажлыг аажмаар хийжээ.

Өмнөд Солонгос маш бага эзэмшил газартай. Нийт тариалангийн талбай нь 2, 12 сая га. Үүнээс усалгаагүй нь 1, 35 сая га, усалгаатай нь 0, 77 сая га юм. Хөдөө аж ахуй нь үндэсний нийт бүтээгдэхүүний II хувийг үйлдвэрлэх бөгөөд солонгосын ажиллах хүчний тавны нэг нь энд ажилладаг. Эдэлбэр газрыг газар эзэмшигч тариачдад тэгш хуваасан байна. Нэг тариачин өрхөд 1, 2 га эдэлбэр газар ногдоно. 3 га хэмжээний талбайтай фермүүд нийт газар эзэмшигчийн 2-оос доошгүй хувийг эзэлнэ. Энэ дашрамд тэмдэглэхэд Өмнөд Солонгосын газар нутгийн дийлэнх нь хувийн өмчинд байх бөгөөд зөвхөн 25-30 хувь нь улсын мэдэлд байна.

Засгийн газар хөдөө аж ахуйн салбарыг тэтгэж, импортыг эзлэх болохоор хязгаарладаг. Боловсрол, сургалт дээд түвшинд байгаа нь фермийн техникийг боловсронгуй болгоход нэлээд тус нэмэр оруулж байна. Хөдөө аж ахуйн салбарт алдагдалтай ажилладаг фермерүүдэд улсаас хөрөнгийн туслалцаа үзүүлэн сайн ажиллуулж бөгжүүлэх бодлого барьдаг. Хөдөө аж ахуйн салбар эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд хүнсний бүтээгдэхүүн, түүний дотор үр тарианыхаа гуравны нэгийг импортоор авч байна. Махны болон сүүний чиглэлийн 2 сая гаруй үхэртэй, 4, 8 сая гаруй гахайтай. Шувууны аж ахуй нэлээд хөгжсөн. 5 сая 600 мянга гаруй тахиа үржүүлж байна. Экспортын орлогын 2 хувийг эзлэх загсны том аж ахуйтай. Жилдээ 1380 тонн загас авна.

Ерөнхийлөгч, засгийн газрын шууд удирдлагаар 1970 онд эхэлсэн Солонгосын шинэ төсгөн хөдөлгөөн нь хөдөө нутгийн тэднийг нийт улс орны нүүр царайг өөрчлөхөд чухал үүрэг гүйцэтгэжээ. Хүнсний бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, тариачдын орлогыг нэмэгдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хот төсгөний хоорондын ялгааг багасгах, хөдөөгийн хөдөлмөрчдийн сэтгэлгээг өөрчлөх зорилт тавьсан энэ хөдөлгөөн үүргээ нэр төртэй биелүүлжээ. Эдүгээ эхэ хөдөлгөөн олон улсын шинэ чанартай болж байна.

Солонгосыг хөгжингүй орнуудтай харьцуулахад тус орны байгаа хүн амдаа тэнцвэртэй хуваагдсан байдаг. Түүнчлэн хүн амын нэлэнх нь эрчимтэй ажиллах хүсэлтэй. Ажиллах хүчний зохих нөсцтэй. Өмнөд

Солонгост хүн амын дундаж наслалт эрэгтэй 62, эмэгтэй 69 байна. Хүн амын жилийн өсөлт 0,9 хувь, хүүхдийн эндэгдэл /1000 хүүхэд тутмаас/ 21, гэр бүл салалт 0,64 хувь, 15-аас дээш насны хүмүүсийн 92,7 хувь нь бичиг үсэгт тайлагджээ. Одоогийн байдлаар нэг эмчид 1216 хүн ногдож байна. 3 хүн тутамд нэг телефон цэг ногдож байна. /1992 оны байдлаар/

НҮБ-ын хөгжлийн программаас явуулсан судалгаанаас үзэхэд хүний хөгжлийн түвшингээр Өмнөд Солонгос дэлхийн 160 орноос 35-д орж байна. Өмнөд Солонгосын эдийн засгийн хөгжил гадаад зохистой нөхцөлөөс шалтгаалан сүүлийн хэдэн жилд онцгой өсөлттэй байв. Гадаад тааламжтай нөхцөлийн гол зүйл нь цахилгаан эрчим хүчний үнэ доогуур, олон улсын зээлийн хүүгийн ачаалал багассан явдал юм.

Эдийн засгийн эрчимтэй хөгжлөөс ажилгүйдэл 1985 онд 4 хувь байсан бол 1988 онд 2 хувь болж буурчээ. Ажилчдын эрх ашгийг хамгаалсан үйлдвэрчний зөвлөлүүд хүчээ авч нэр хүнд өссөн. Үүний үр дүнд ажилчдын цалин хөлс өсч байна. Ажилчдын цалинг 1987 оныхтой харьцуулбал 1988 онд 28 хувиар өссөн байв.

Хөдөөгийн хүн амын сарын дундаж орлого нь 786 мянга 333 вон болж нэмэгдсэн бол дундаж зарлага нь 605 мянга 166 вон болжээ. Хотын хүн амын сарын дундаж орлого нь 804 мянга 938 вон. Тэдний сарын дундаж зарлага нь 632 мянга 251 вон орчим байдаг ажээ.

Сүүлийн үед жуулчлал эрчимтэй хөгжиж, худалдааны тэнцлийн ашигтай зөрүү өсч мөнгөний эргэлт нь 14,3 тэрбум ам.долларт хүрч үндэсний нийт бүтээгдэхүүний 9 хувийг эзлэх болов. Аялал жуулчлалын түшиц газар болох Чэжү арал гэхэд л жилдээ 3 сая жуулчин хүлээн авдаг байна. Энд Чонмун гэдэг аялал жуулчлалын 25 салбартай том байгууллага байдаг. 22 зочид буудалтай. Чэжүд жуулчлалын улиралд өдөр бүр 30 удаа онгоц бууж жуулчдад үйлчилдэг байна.

БНСУ өнөөдөр дэлхийн гол 10 экспортлогч орны нэг болж телевизор үйлдвэрлэлээр дэлхийд I, хөлөг онгоцоор II, гутал, төрөл бүрийн бэлэн хувцас, гэр ахуйн цахилгаан бараагаар III, нэхмэл, бөс бараагаар IV, Азийн "шинээр үйлдвэржсэн орнууд" дотор цахилгаан, цахим техникийн бараагаар V байранд орж байна.

Тус улсын үндэсний нийт бүтээгдэхүүн үнийн дүнгээр 1990 онд 21 тэрбум ам.долларт хүрч 1962 оныхоос 26 дахин өсчээ. Нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн 1962 онд 87 ам.доллар байсан бол эдүгээ 5000 гаруй ам.доллар болсон бөгөөд энэ нь дэлхийн дунджаас даруй 2 дахин их байна. Энэ зууны эцэс гэхэд одоогийнхоос нэг дахин нэмэх зорилт тавьж байна.

Солонгосын эдийн засаг сүүлийн 20 гаруй жилд дунджаар жилд 8 хувийн хурдацтай хөгжиж байснаа ойрын хэдэн жилд 12,1 хувийн хурдацтай байна.

БНСУ цэргийн хатуу манга дэглэмийн нөхцөлд зах зээлийн эдийн засгийн ул үндэс сайтай, ухаалаг тууштай бодлого явуулсны үр дүнд хөгжлийн ийм түвшинд хүрчээ. Эдийн засгийн эрс зоригтой өөрчлөлт, огцом үсрэлт хийдээ доорхи гол ачхмыг дорвитой шийдэмгий хийсэн гэж үздэг байна. Энэ нь төрөөс эдийн засгийг удирдан зохицуулах ажлыг зохион байгуулахдаа юуны өмнө мөнгөний ханшийг унагалгүйгээр худалдаа төлбөрийн гэнцлийг зөв барьж чадсан, гадаадын хөрөнгө оруулалтыг чадамгай ашиглаж, дотоодын хуримтлалыг нэмэгдүүлэхийг зохих ёсоор урамшуулах арга хэмжээ авсан, өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд хүү багатай зээл олгох явдлыг их анхаарсан, гадаадын тэргүүний техник, технологи, дэвшилттэй шинэ зүйлсийг худалдан авах, тэдгээрийг дотооддоо боловсронгуй болгох ажлыг чадамгай хослуулсан, улс орныг үйлдвэржүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар үр өгөөж сайтай хэрэгжүүлсэн зэрэг болно.

Амжилтанд хүрсэн бас нэг уг сурвалж нь дээд зэргийн сахилга, зохион байгуулалт, хүн ардынх нь оюун ухааны болон бие бялдрын чадвар идэвх, хичээнгүй зүтгэл, мөрийлт, хөдөлмөр зарцуулалтын нэн

бага хэмжээ, хүссэн зорьсондоо хүрэхийн төлөө шантарч цохрөлгүй тэмүүлэх үндэсний онцлог чанар зэргийг энд хэлэхгүй өнгөрч болохгүй бизээ.

Өнөөдөр БНСУ ийнхүү хөгжлийн зохих түвшинд хүрсэн хэдий ч Өрнөдөд төлөх өр багагүй, 1991 оны байдлаар гадаад өр 37 тэрбум ам. доллар байв. Түүнчлэн үндсэн нэрийн олон түүхий эдийн хувьд гадаадаас их хамаарал, өрсөлдөгч том гүрнүүдийн зүгээс эдийн засгийн зарим даралт шахалт үзүүлдэг, улс төрийн байдал зарим үед тогтворгүйгдэг зэрэг олон таагүй нөхцөл байдаг ажээ.

БНСУ 60-аад оноос хүн амынхаа боловсролын түвшинд "хувьсгал хийх" цогц бодлого авч хэрэгжүүлсэн байна. Эхний үед ардын сургуулийн хоёр шаттай зургаан жилийн сургалтын системийн бүх зардлыг улс дааж байжээ. Ардын сургуулийг дүүргэсэн хүн бүр тусгай мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол эзэмших гурван жилийн сургалтад хамрагдаж байв. Одоогийн боловсролын тогтолцоо нь улсын, хувийн гэсэн сургалтын хоёр хэлбэртэй. Энэ хэлбэр цэцэрлэгээс эхлээд сургалтын бүх шатанд үйлчилнэ. Сургалтын систем нь 6 жилийн сургалттай бага сургууль, 3 жилийн сургалттай бүрэн бус дунд сургууль, 3 жилийн сургалттай бүрэн дунд сургууль, 4 жилийн сургалттай коллеж, их дээд сургуулиудаас бүрддэг.

Улсын бага, дунд сургуульд үнэ төлбөргүй, их дээд сургуульд төлбөртэй сурлана. Хувийн бүх шатны сургалт төлбөртэй. БНСУ сургалтынхаа чанараар дэлхийд айргийн тавд ордог. Дээд боловсрол эдүгээ солонгос иргэн бүрийн амьдралын нэн чухал хэрэгцээ болж байна. Дунд шатны сургууль төгсөгчдийн 90 гаруй хувь нь тусгай дунд, их дээд сургуульд элсч байна. Энэ үзүүлэлтээрээ АНУ-ын дараа орж байна. Их мөнгө төлдөг хэдий ч хүмүүс мэдлэг мэргэжилтэй болъё гэж үнэн сэтгэлээсээ тэмцдэг болгохыг энэ баримт харуулж байна. Энэ нь улс орны хөгжлийн өнөөгийн түвшинд хүн бүр зохих боловсрол, нарийн мэргэжил эзэмшсэн байх нийгмийн зайлшгүй шаардлагаас урган гарч байна. Өнөөдөр БНСУ-д боловсрол, мэргэжилгүй хүнд ажил олдэх нь нэн бэрхшээлтэй.

1989 оны байдлаар төрөл бүрийн шатны сургуульд 11, 4 сая хүн, түүнээс нэг сая гаруй хүн их дээд сургуульд суралцаж байв.

БНСУ бие даасан, үндэснийхээ эрх ашгийг дээдэлсэн гадаад бодлого баримталдаг.

1988 оны долдугаар сард БНСУ-ын Засгийн газар гадаад бодлогоддоо шинэчлэлт хийж, хуучин социалист гэгдэж байсан бүү оронтой харилцаа тогтоох шийдвэр гаргаж "Умардын хөгөлбөр" хэмээх гадаад бодлогын чиглэл боловсруулж, дэлхийн улс гүрэнтэй харилцахдаа үзэл суртал, шашин шүтлэг, том багын аливаа ялгааг харгалзахгүй, тухайн орны эрхнийг хүндэтгэх зарчмыг үндэс болгохоо тунхагласан билээ. Гадаад бодлогын энэ шинэ чиг шугам амжилттай хэрэгжиж байна. Өнөөдөр БНСУ хуучин социалист гэгдэж байсан Ази, Зүүн европын бараг бүх оронтой харилцаа тогтоогоод байна. Эдгээр оронтой тогтоосон БНСУ-ын харилцааны нэг онцлог шинэ гэвэл харьцангуй богино хугацаанд нийгмийн амьдралын төрөл бүрийн салбарыг хамарч идэвхтэй байдлаар өрнөж буй явдал юм.

БНСУ дэлхийн болон бүс нутгийн үйл амьдралд идэвхтэй оролцож, гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурь нь улам бүр өсч байна. Өмнөд Солонгос НҮБ-ын 17 төрөлжсөн байгууллагатай хамтарч ажилладаг. Түүнээс гадна олон улсын 54 байгууллагын гишүүн орон юм.

БНСУ Зүүн хойт Азийн бүс нутагт энх тайван эв нэгдлийг бэхжүүлж тогтворжуулах, Солонгосын хойгийн гүшүүртэй байдлыг нэгжлэхэд хүчин чармайлт тавьж ирэв. Үүний үр дүнд Умард Солонгостой эвлэрэх, харилцан итгэлцэх, хамтын ажиллагаа хөгжүүлэх, солилцоогоо өргөтгөх талаар тодорхой тохиролцсонд хүрч, Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгох тухай тунхаглал гаргасан билээ.

БНСУ солонгосыг хоёр хэсгийг эв эээр нэгтгэж, үндэсний эв нэгдлийг

бэхжүүлэхэд чиглэсэн идэвхтэй гадаад бодлогоо баримталж байна.

Монгол улс, БНСУ-ын хооронд 1990 оны гуравдугаар сард дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр орны эдийн засаг, худалдаа, соёл боловсрол, шинжлэх ухаан, спорт, мэдээлэл, жуулчлал, олон нийтийн болон иргэний байгууллагуудын хоорондох хамтын ажиллагаа хурдацтай өрнөж байна. Харилцааны явцын тухай тэмдэглүүштэй нэг онцлог шинж гэвэл харилцангуй богино хугацаанд олон талыг хамарч нэлээд идэвхтэй байдлаар өргөжиж буй явдал юм. Харилцаа тогтоосноос хойшхи богино хугацаанд парламент, Засгийн газар, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, олон нийтийн байгууллагуудын төлөөлөгчид харилцан айлчилж, аянчин гийчид олноор зочилж, мэргэжил дээшлүүлэгчид, туршлага судлаачид, оюутан аспирант цөөнгүй ирж очиж улмаар 1991 онд БНСУ-ын Ерөнхийлөгчийн урилгаар Монгол улсын Ерөнхийлөгч, мөн гадаад харилцааны сайд БНСУ-д айлчилж хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойллоо. Түүнчлэн 1992 оны дөрөвдүгээр сард БНСУ-ын Гад ад явдлын яамны сайд манай оронд айлчиллаа.

Өнгөрсөн хугацаанд Монгол улс, БНСУ-ын засгийн газар хоорондын эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны тухай, хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжиж харилцан хамгаалах, худалдаа бараа солилцсоны хэлэлцээрийг хоёр тал найдвартай биелүүлэх, соёлын харилцааг хөгжүүлэх, агаарын харилцаа тогтоох, Дипломат болон албан паспорттай иргэдийг визээс харилцан чөлөөлөх, татварыг давхардуулж оногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдал гаргуулахгүй байх, солонгосын сайн дурынхныг Монголд ажиллуулах зэрэг гэрээ, хэлэлцээрүүд байгуулагдсан нь харилцааны эрх зүйн үндсийг бүрэлдүүлэхэд чухал ач холбогдолтой боллоо.

Хөрөнгө оруулалтын тухай хэлэлцээрт: хөрөнгө оруулсан тохиолдолд манай тал Солонгос улсыг ашгийн татвараас чөлөөлөх, газар ашигласны төлбөрийг хөнгөлөх, шинэ тэргүүний техник нэвтрүүлбэл урьд ногдсон татварын 30 хувийг эргүүлж өгөх, түүхий эд, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх зэрэг хөнгөлөлтүүд тусгагджээ. Одоо манай улс экспортоор бөмбөгөн болон боловсруулсан ноолуур гаргаж оронд нь бэлэн хувцас гэр ахуйн цахилгаан бараа, суудлын автомашин, жижиг автобус авч байна.

Хоёр орны хамтын ажиллагааны нэг гол чиглэлийг солонгосын туршлагаас бүтээлчээр суралцах явдал гэж тодорхойлж болох юм. Энэ ажлын хүрээнд манай улсын иргэд Солонгост очиж, дадлага сургууль хийж, мэргэжил эзэмшиж байна.

Бүс нутгийн болон олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагад оролцох манай улсын оролцоог нэмэгдүүлэхэд БНСУ зохих дэмжлэг тусалцаа үзүүлж байна.

Ерөнхийлөгчийн айлчлалтын үеэр БНСУ-аас манай улсад нэг сая ам. долларын буцалтгүй тусламжийн хүрээнд өргөн хэрэглээний бараа нийлүүлэхэр тохирсноо Солонгосын тал эдүгээ нэгэнт хэрэгжүүлээд байна. Мөн 10 сая ам. долларын урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгохоор болсон юм. Хандивлагч орнуудын Токиогийн 1992 оны ээлжит уулзалтын үеэр БНСУ урьд үзүүлсэн зээл дээрээ нэмж 4 сая ам. доллар олгохоор болсон юм. Үүний зэрэгцээ 250 мянган ам. долларын хүнс, 400 мянган ам. долларын техникийн тусалцаа нийтдээ 650 мянган ам. долларын тусламж үзүүлэхээр болсон билээ. Монгол, БНСУ-ын худалдааны эргэлт 1990 онд 1988 оныхоос 24 дахин өсч 2,5 сая ам. доллар байснаа 1991 онд 5,7 сая болжээ. Үүнийг 1992 оны зургадугаар сард болсон Монгол, БНСУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааны хоёр талын хамтарсан хуралдаанаар авч хэлэлцээд хоёр орны эдийн засгийн нөөц боломжтой харьцуулахад хангалтгүй байна гэж үзсэн. Хуралдаанаар Монголд боломжтой бүтээгдэхүүний үйлдвэрлэл бий болгох замаар экспортын барааны нэр төрлийг өлшрүүлж худалдааг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэр байгуулахад зориулж худалдааг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулах боломжийг судлахаар тохиролцсон байна.

БНСУ-ын олон пүүс компани монголд хэрэнгө оруулж хамтарч ажиллах сонирхолтой байна. Эдгээрийн дотроос дэлхийд нэрд гарсан Самсунг компани, "ДЭҮ" корпорацийг дурьдаж болох юм.

Самсунг компани манай оронд сав баглаа боодлын үйлдвэр, болон жилдээ нэг удаагийн тариур 30 сая, зүү 120 саяыг гаргах хүчин чадалтай хамтын үйлдвэр байгуулахаар хэлэлцээр байгуулсан. Мөн хэд хэдэн нэр төрлийн өргөн зэрэгцээний барээ нийлүүлжээ. "ДЭҮ" корпораци Монголд холбооны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж зээлдэр олгож манай байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Урт хугацаатай хөнгөлөгтэй зээлийн хүрээнд хавтгай цилний үйлдвэр байгуулахад болон бусад салбарт хамтран ажиллахад "ДЭҮ" корпораци чухал үүрэг гүйцэтгэх төлөвтэй байна.

Хоёр орны эдийн засгийн нөхцөл байдал нь бие биеэ нэхэх өргөн боломжтой юм. Үүнийг оновчтой хөснүүлж чадвал харилцан эшигтай хамтын ажиллагаа өргөжин гүнзгийрэх нь дамжиггүй.

1. A Handbook of Korea, Seoul, 1990
2. Facts about Korea, Seoul, 1991
3. Dependent Development in Korea, Seoul, 1989.
4. Republic of Korea: a market for products from other developing countries, Geneva, 1983.
5. В. Н. Лаврентьев. Новые индустриальные страны Азии: перестройка промышленной структуры. М., 1990.
6. В. Д. Андрианов. "Новые индустриальные страны" в мировом капиталистическом хозяйстве. М., 1989.
7. "Проблемы Дальнего Востока", - № 5, 1990.
8. "Зах зээл" сэтгүүл, 1991, № 3
9. "Дорно, өрнө" /сэтгүүл/, 1991, № 3
10. "Үнэн" 1991. 9. 26. 10. 23.
11. "Засгийн газрын мэлээ" 1992. № 13, 18
12. "Ардын эрх" 1992. 9. 26.